



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ



СТАТИСТИКИЙН ӨВРИЙН ДЭВТЭР

2018 он



- Аймгийн ерөнхий мэдээлэл
- Хүн амын үндсэн үзүүлэлт
- Дотоодын нийт бүтээгдэхүүн
- ААНБ-ын тооллогын үзүүлэлт
- Эрүүл мэндийн зарим үзүүлэлт
- Ажил эрхлэлтийн зарим үзүүлэлт
- Боловсролын зарим үзүүлэлт
- Мал аж ахуйн зарим үзүүлэлт
- Аймгийн холбоотой ВЭБ хуудас



1931 онд Цэцэрлэг Мандал уулын аймгийн гол хошуудаас одоогийн Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан 31 сум бүхий нэг том аймгийг Түйн голын цагаан эрэгт байгуулж байжээ.

Өвөрхангай аймаг нь Монгол улсын төв хэсэгт оршдог бөгөөд 19 сум, 111 багтай ба урд талаараа Өмнөговь, Дундговь баруун талаараа Баянхонгор, хойд талаараа Архангай, зүүн талаараа Булган, Төв аймгуудтай тус тус хиллэн оршдог. Улаанбаатар хотоос 430 км зайтай. 62 895.0 мянган кв.км нутаг дэвсгэртэй. 2017 оны жилийн эцсийн байдлаар 115 684 хүн амтай, үүнээс 42 912 хүүхэд багачууд амьдарч байна.

Уур амьсгал

Байгаль цаг уурын хувьд эрс тэс, эх газрын уур амьсгалтай, өвөлдөө хангайн бүсээр -40-43 хэм, тал хээр, говийн бүсээр -35-39 хэм хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь хангайн бүсээр 14-17 хэм, тал хээр, говийн бүсээр 18-22 хэм хүрдэг. Салхины хурд 5-8 м/сек, жилд дунджаар 265 мм хур тунадас унадаг.



Ёс заншил, өв уламжлал

Өвөрхангай аймгийн онцлог соёлын биет бус өв

- Монгол ардын уртын дуу
- Уриа дуудлага, ерөөл магтаал
- Морин хуур
- Хоолойн лимбэ
- Хөөмий
- Монгол үндэсний уран хатгамал, зээгт наамал
- Уран нугаралт
- Битүү амьсгаагаар лимбэ тоглох
- Монгол үндэсний хээ угалз
- Уран сийлбэр зэрэг онцлог өв олонтой.

Өвөрхангай аймгийн хэмжээнд соёлын биет бус өв уламжлагч 164 хүн бүртгэлтэй байгаа бөгөөд соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билэг авьяастан улсын жагсаалтад 12 байна.



Биеийн тамир, спорт

- Биеийн тамир спортын байгууллага 2
 - Нийт ажиллагчид 34
 - Эмэгтэй 12
- Биеийн тамир, спортоор хичээллэгчид 41375
- Спорт заал 39
- Цол, зэрэгтэй тамирчид 712
 - Дасгалжуулагчид 96
 - Олон улсын мастер 6
 - Спортын мастер 124
 - Спортын дэд мастер 95
 - Цол зэрэгтэй шүүгчид 3



Биеийн тамир, спорт

- Өвөрхангай аймгаас төрөн гарсан улсын цолтой бөхчүүд 29, олон улсын хэмжээний мастер 6, спортын мастер 124, спортын дэд мастер 95, спортын зэрэг цолтон 712, улсын шүүгч 3 байна.
- Тив, дэлхий, олон улс, монголын бүх ард түмний спартикад, хүүхдийн спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнээс жилд 170 гаруй медаль хүртэж байна.



Биеийн тамир, спорт

- 2016 онд Өсвөрийн улсын аварга шалгаруулах, Олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хөнгөн атлетик, жудо бөх, чөлөөт бөх, үндэсний бөх, үндэсний сур, волейбол, сагсан бөмбөг, байт харваа, таеквондо, спорт бүжиг, теннис, дугуй, бадминтон, шагайн харваа, спорт аялал гэсэн 15 төрлөөр 400 гаруй тамирчин амжилттай оролцож, алт-150, мөнгө-161, хүрэл-199 нийт-510 медаль хүртсэн байна.
- Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 10 төрлөөр насанд хүрэгчдийн аймгийн аваргаас шалгарсан баг тамирчид Улсын аварга шалгаруулах тэмцээнд шагайн харваа, үндэсний бөх, үндэсний сур, волейбол, сагсан бөмбөг, хөнгөн атлетик, явган аялал, теннис гэсэн спортын арван төрлөөр 350 гаруй тамирчин амжилттай оролцож алт-47, мөнгө-32, хүрэл-68, нийт-145 медаль авсан байна.



Соёл, сүм хийд

- Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт 44
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчид 32747
- Нийтийн номын сан 19
- Нийтийн номын сангийн суудал 114
- Номын сангийн байнгын уншигчид 7971
- Сүм хийд 15
 - Будда 13
 - Христ 2



Нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ

- Уянга сум “Эрээлж будсан Монгол гэр”
- Бат-Өлзий сумын сарлагын өрөм
- Сант сумын ямааны ааруул
- Баянгол сумын “Баянгол омгийн хонь”
- Бүрд, Баян-Өндөр, Өлзийт сумдын айраг
- Баруунбаян-Улаан сумын Халтар арвай
- Хархорин сумын Чацаргана
- Нарийнтээл сумын Тээлийн улаан ямаа
- Нарийнтээл сумын Ширхинцэг сортын байцаа
- Богд сумын Ажийн бор ааруул зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд аймгийн брэнд бүтээгдэхүүнээр шалгарчээ.



Тээвэр, харилцаа холбоо

- Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машин бүгд
 - 8785
- Суудлын авто машин
 - 5221
- Ачааны автобус
 - 3048
- Автобус
 - 450
- Тусгай зориулалтын
 - 66
- Ашигласан хугацаагаар: 3 жил хүртэл 439
 - 4-9 жил 688
 - 10-аас дээш жил 7658



Барилга, орон сууц, нийтийн аж ахуй

- Дотоодын барилгын байгууллагуудын гүйцэтгэсэн барилга угсралт их засварын ажил
 - 9230411.7 мян.төг
 - Үүнээс: Барилга угсралт 8615701.3 мян.төг
 - Их засвар 614710.4 мян.төг
- Орон сууцанд амьдардаг өрхийн тоо
1698
- Ус түгээсэн цэгийн тоо
 - 98
- Зөөврийн ус хэрэглэдэг өрх
 - 32150
- Ус тээврийн машины тоо
 - 11
- Хог устгах цэг
 - 24
- Хог тээврийн машины тоо
 - 28
- Халуун усны цэгийн тоо
 - 37



Байгаль орчин

- Ойн сан бүхий газар 150.8 (мян.га)
 - Ойн модоор бүрхэгдсэн газар 129.4
 - Ой модыг огтолсон газар 6.0
 - Мод үржүүлгийн газар 0.1
 - Ой тэлэн ургах нөөц газар 13.2
 - Ойн сангийн бусад газар 2.1
- Гадаргын ус нийт гол горхи 159
 - Тасарсан 9
 - Ширгэсэн 28
- Рашаан нийт 16
- Булаг 750
 - Ширгэсэн 73
- Нуур, тойром 54
 - Ширгэсэн 21



Гэмт хэрэг

- Бүртгэгдсэн гэмт хэрэг бүгд **492**
- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг **139**
- Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг **9**
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг **247**
- Малын хулгайн гэмт хэрэг **41**
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг **45**
- Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч **425**
 - Эмэгтэй **33**
 - 18 хүртэлх насны **29**
- Шүүхээр шийтгүүлсэн хүн **266**



Мөнгө, банк

- Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл
 - 109892.1 (сая.төг)
- Зээлийн өрийн үлдэгдэл
 - 168949.9 (сая.төг)
- Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл
 - 2109.6 (сая.төг)



Төрийн санхүү

- Орон нутгийн төсвийн нийт орлого
 - 73916.2 (сая.төг)
- Орон нутгийн төсвийн нийт зарлага
 - 73752.3 (сая.төг)
- Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг
 - 44805.1 (сая.төг)
- Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг
 - 2393.4 (сая.төг)



Хүн ам зүй

Хүн ам зүй нь математик тооцоолол, загвар боловсруулахтай холбоотой. Тухайлбал: Хүн амын өсөлт, өөрчлөлтөнд нөлөөлөх 3 бүрэлдэхүүн хэсэг болох

- Төрөлт
- Нас баралт
- Шилжилт хөдөлгөөний үзүүлэлтүүд

Тэдгээрийн хүн амын өсөлт, өөрчлөлтөнд нөлөөлөх нөлөөллийг тооцдог. Өөрөөр хэлбэл, хүн ам зүйн үзэгдлүүдийн хоорондох тоон уялдааг бусад үзэгдлүүдтэй хамаарах талаас нь тайлбарлахаас илүү тодорхойлон өгүүлэх, задлан шинжлэх онцлогтой.



Хүн ам судлал

Хүн ам судлал нь хүн ам зүйн үзэгдлүүдийн уялдаа холбоог нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй, социологи, антропологи, газар зүй зэрэг бусад салбар шинжлэх ухаантай нягт уялдуулан авч судалдаг.

Өөрөөр хэлбэл хүн ам, төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнд гарч буй өөрчлөлтийг бусад нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлстэй хэрхэн уялдаж байгааг судалдаг.

Хүн ам судлалын судалгааны ажлууд нь цэвэр хүн ам зүйн шинж чанартай, зарим нь эдийн засгийн буюу түүхийн шинж чанартай ч байж болно. Тиймээс ч эдийн засгийн хүн ам зүй, түүхийн хүн ам зүй, антропологийн хүн ам зүй гэх мэт ойлголтуудыг эрдэмтэд өргөн хэрэглэдэг байна.



Хүн амын хүйс

Хүн амын бүтцэд хүн амын нас, хүйсийн байдал чухал байр суурь эзэлдэг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийн өөрчлөлт, түүний шалтгаан зэрэг нь тухайн улс орон, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдалтай уялдсан байдаг.

Хүн амын төрөлт

Төрөлт нь хүн ам зүйн судалгаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг судалгааны чиглэлүүдийн нэг юм.

Хүн амын нас баралт

Нас баралт нь хүн амын бодит өсөлтөнд нөлөөлдөг гол үзүүлэлтүүдийн нэг юм.




Хүн амын тоо, насны бүлгээр, 2017 он, сумдаар

Сумдын нэр	Нийт хүн ам	0-14	15-64	65+	Эрэмбэ
Арвайхээр	31487	9701	20341	1445	I хамгийн их
Баруунбаян-Улаан	2803	901	1809	93	
Бат-Өлзий	7499	2443	4837	219	IV
Баянгол	3939	1109	2674	156	
Баян-Өндөр	3816	1112	2485	219	
Богд	5626	1854	3612	160	
Бүрд	2951	849	1932	170	
Гучин-Ус	2195	638	1478	79	XIX хамгийн бага
Есөнзүйл	3115	927	2013	175	
Зүүнбаян-Улаан	4066	1208	2696	162	
Өлзийт	2446	720	1560	166	
Нарийнтээл	3663	1027	2511	125	
Сант	3644	1073	2409	162	
Тарагт	3373	949	2286	138	
Төгрөг	2764	849	1820	95	
Уянга	9512	2967	6258	287	III
Хайрхандулаан	3518	1023	2348	147	
Хархорин	12516	3519	8258	739	II
Хужирт	6751	2024	4354	373	V
Нийт	115684	34893	75681	5110	



Хүн амын нас, хүйсийн суварга





Насны бүлгийн эзлэх хувь, хүйсийн харьцаа, 2017 он, сумдаар

Сумдын нэр	Нийт хүн амд хүүхдийн эзлэх хувь	Хөгшидийн эзлэх хувь	Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь	Хүйсийн харьцаа	Эрэмбэ
Арвайхээр	30.8	4.6	64.6	92.4	XV хамгийн бага
Баруунбаян-Улаан	32.1	3.3	64.5	100.2	
Бат-Өлзий	32.6	2.9	64.5	98.9	
Баянгол	28.2	4.0	67.9	100.9	
Баян-Өндөр	29.1	5.7	65.1	99.9	
Богд	33.0	2.8	64.2	102.9	
Бүрд	28.8	5.8	65.5	105.5	II
Гучин-Ус	29.1	3.6	67.3	100.8	
Есөнзүйл	29.8	5.6	64.6	105.5	II
Зүүнбаян-Улаан	29.7	4.0	66.3	105.7	I хамгийн их
Өлзийт	29.4	6.8	63.8	103.3	
Нарийнтээл	28.0	3.4	68.6	102.8	
Сант	29.4	4.4	66.1	104.0	IV
Тарагт	28.1	4.1	67.8	105.4	III
Төгрөг	30.7	3.4	65.8	101.6	
Уянга	31.2	3.0	65.8	100.3	
Хайрхандулаан	29.1	4.2	66.7	103.6	V
Хархорин	28.1	5.9	66.0	99.6	
Хужирт	30.0	5.5	64.5	102.4	
Нийт	30.2	4.4	65.4	100.8	




Хүн ам, сумаар 1990 – 2017 он

Сумдын нэр	1990	1995	2000	2005	2010	2015	2017	Эрэмбэ
Арвайхээр	18080	20465	20782	23835	27560	30702	31487	I хамгийн их
Баруунбаян-Улаан	2251	2700	2934	2522	2638	2722	2803	
Бат-Өлзий	4279	5032	5713	5955	6381	7234	7499	IV
Баянгол	3452	4485	4775	3911	4423	3822	3939	
Баян-Өндөр	3861	4622	4867	3665	4262	3818	3816	
Богд	4186	5214	5947	5505	5363	5374	5626	
Бүрд	4481	4340	3901	3312	3041	2867	2951	
Гучин-Ус	2133	2282	2418	1913	2238	2161	2195	XIX хамгийн бага
Есөнзүйл	3234	3718	3737	3392	3242	3023	3115	
Зүүнбаян-Улаан	5474	5786	5431	4314	4166	3945	4066	
Өлзийт	3177	3588	3454	2649	2739	2455	2446	
Нарийнтээл	3229	3819	4335	3710	3719	3548	3663	
Сант	3324	4089	4328	3711	3434	3551	3644	
Тарагт	4947	5109	4785	3597	3272	3220	3373	
Төгрөг	2500	2866	2953	2718	2766	2651	2764	
Уянга	5950	7379	7549	10273	9659	9429	9512	III
Хайрхандулаан	3425	4150	4105	3253	3473	3357	3518	
Хархорин	11404	13399	13814	13015	12933	12265	12516	II
Хужирт	8418	8518	7814	6985	6811	6630	6751	V
Нийт	97805	111561	113642	108235	112120	112774	115684	



Хүн амын дундаж наслалт, хүйсээр



Хүн амын дундаж наслалт 69.85 байгаа нь урьд оноос 0.3-аар өссөн үзүүлэлттэй байна. Эмэгтэйчүүдийн дундаж наслалт 72.65 байгаа бол эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс 5.31 насаар бага буюу 67.31 байна.




Өрх, сумаар 2005 – 2017 он

Сумдын нэр	2005	2010	2015	2016	2017	Эрэмбэ
Арвайхээр	5566	7788	8840	8864	9097	I хамгийн их
Баруунбаян-Улаан	624	704	711	719	718	
Бат-Өлзий	1716	2103	2186	2193	2229	IV
Баянгол	1145	1270	1128	1158	1174	
Баян-Өндөр	1118	1260	1166	1159	1169	
Богд	1354	1407	1433	1447	1484	
Бүрд	832	825	832	847	858	
Гучин-Ус	574	600	609	623	637	XIX хамгийн бага
Есөнзүйл	948	962	914	909	929	
Зүүнбаян-Улаан	1332	1292	1238	1261	1302	
Өлзийт	860	834	736	740	766	
Нарийнтээл	984	1040	1024	1025	1060	
Сант	1148	1101	1023	1032	1041	
Тарагт	1087	829	1050	1087	1094	
Төгрөг	768	831	798	820	824	
Уянга	2475	2823	2828	2815	2834	III
Хайрхандулаан	1004	1050	1068	1106	1114	
Хархорин	3279	3800	3754	3785	3828	II
Хужирт	1979	1932	1937	1950	1992	V
Нийт	28793	32451	33275	33540	34150	



2017 онд монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.6 хувь, хангайн бүсийн 12.1 хувь болох 463.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.


Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4.0 сая төгрөг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дүнгээр 100.6 тэрбумд хүрсэн байна.





ДНБ-ийг салбараар авч үзвэл: ХАА, ан агнуур, ойн аж ахуйн салбар 47.0 хувь, Аж үйлдвэр, барилгын салбар нь 21.7 хувь, Үйлчилгээний салбар 31.3 хувийг тус тус эзэлж байна. Нэг хүнд ногдох ДНБ нь 2014 онд 3.5 сая, 2015 онд 3.6 сая, 2016 онд 3.6 сая, 2017 онд 4.0 сая төгрөгт хүрсэн байна.

ДНБ-д эзлэх салбаруудын
эзлэх хувь





Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

Сумдын нэр	1998	2006	2011	2016	Эрэмбэ
Арвайхээр	304	234	374	742	I хамгийн их
Баруунбаян-Улаан	11	20	21	19	XIX хамгийн бага
Бат-Өлзий	23	31	44	72	III
Баянгол	16	22	23	31	
Баян-Өндөр	11	21	34	39	
Богд	18	19	22	37	
Бүрд	17	15	11	19	XIX хамгийн бага
Гучин-Ус	13	20	19	30	
Есөнзүйл	15	19	21	30	
Зүүнбаян-Улаан	26	22	25	34	
Өлзийт	11	14	18	27	
Нарийнтээл	19	21	27	39	
Сант	14	20	18	22	
Тарагт	16	14	20	32	
Төгрөг	13	25	31	27	
Уянга	18	30	59	71	IV
Хайрхандулаан	12	17	16	27	
Хархорин	66	94	88	156	II
Хужирт	31	35	42	58	V
Нийт	654	693	913	1512	



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА – 2016 ОН

Аж ахуйн нэгж, байгууллагын тоо
1512

Аж ахуйн нэгж
1125

Төрийн бус
байгууллага
194

Төсвийн
байгууллага
193

2016 оны тооллогод хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагыг төрлөөр нь авч үзвэл: 74.4 хувь нь аж ахуйн нэгж, 12.8 хувь нь төрийн бус байгууллага, 12.8 хувь нь төсвийн байгууллага байна.



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА –ын ажиллагчдын сарын дундаж цалин



631500

мянган төгрөг



605400 МЯН.ТӨГ



650900 МЯН.ТӨГ



Эрүүл мэндийн зарим үзүүлэлт, 1995 – 2017 он

Үзүүлэлт	1995	2000	2005	2010	2015	2017
Их эмч	170	161	186	176	248	258
Эм зүйч	8	9	8	13	27	33
Нэг эмчид ногдох хүн	640	697	664	580	453	445
Нэг сувилагчид ногдох хүн	419	484	469	335	348	350
1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	35.8	28.5	24.9	29.9	14.2	16.1
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	59.6	43.7	0.1	5.0	4.7	4.1
Үр хөндөлт	487	159	98	377	403	203
Халдварт өвчнөөр өвчлөгчид	1459	1843	839	1054	977	1114



Төрөлт, нас баралтын тоо, жилийн эцсийн байдлаар, сумдаар

Сумдын нэр	Төрөлт		Нас баралт		Ердийн цэвэр өсөлт	
	2016	2017	2016	2017	2016	2017
Арвайхээр	1940	1776	236	206	1704	1570
Баруунбаян-Улаан	6	6	17	17	-11	-11
Бат-Өлзий	65	64	42	39	23	25
Баянгол	8	7	11	16	-3	-9
Баян-Өндөр	12	6	25	19	-13	-13
Богд	54	36	46	25	8	11
Бүрд	28	14	16	16	12	-2
Гучин-Ус	7	14	8	7	-1	7
Есөнзүйл	14	21	20	18	-6	3
Зүүнбаян-Улаан	16	9	25	23	-9	-14
Нарийнтээл	10	4	5	15	5	-11
Өлзийт	17	10	14	9	3	1
Сант	10	8	22	15	-12	-7
Тарагт	9	2	16	21	-7	-19
Төгрөг	6	7	14	13	-8	-6
Уянга	79	97	56	49	23	48
Хайрхандулаан	35	21	15	16	20	5
Хархорин	295	284	30	35	265	249
Хужирт	64	42	41	42	23	-
Дүн	2675	2428	659	601	2016	1827



Нийгмийн зарим үзүүлэлт, 1995 – 2017 он

Үзүүлэлт	1995	2000	2005	2010	2015	2017
Төрөлт	2987	2768	2090	2752	2755	2428
Нас баралт	666	609	633	712	621	601
Дундаж наслалт	63.3	63.2	65.1	67.8	69.8	69.8
Бүтэн өнчин хүүхдийн тоо	219	182	188	194	129	105
Хагас өнчин хүүхдийн тоо	2533	2060	2123	1642	1693	1668
Өрх толгойлсон эхийн тоо	-	2180	2585	2856	3397	3730
18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх	-	-	-	-	1641	1803
18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрх	-	-	-	-	2078	2039



2016

2017

3469



3730

Өрх толгойлсон эхийн тоо

108



105

Бүтэн өнчин хүүхдийн тоо

1638



1668

Хагас өнчин хүүхдийн тоо

2290



2278

Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настан

Нийгмийн зарим үзүүлэлт






Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт 2013 – 2017 он

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Хөдөлмөрийн насны хүн ам	72348	70500	71939	72233	72837
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	57707	54445	53360	54398	59694
Ажиллагчид	54817	52538	51415	49583	55180
Ажилгүй иргэд	2890	1907	1945	4815	4514
Бүртгэлтэй ажилгүй иргэд	1822	1799	2047	2482	1160
Ажиллах хүчний оролцооны түвшин	79.8	75.3	72.9	75.5	77.1
Ажил эрхлэлтийн түвшин	75.7	72.7	70.3	68.8	71.3
Ажилгүйдлийн түвшин	5.0	3.5	3.6	8.9	7.6




2017 оны хүн ам, насны ангиллаар



- Хүүхэд (0-14)
- Хөдөлмөрийн насны хүн ам (15-59)
- Тэтгэврийн насны хүн ам (60<)

Ажилгүйдлийн ТҮВШИН





Боловсролын үзүүлэлт

Үзүүлэлт	2005/2006	2010/2011	2015/2016	2016/2017	2017/2018
ЕБСургуулийн тоо	27	30	30	30	30
ЕБС-д өдрийн ангид суралцагчдын тоо (1000 хүн)	24.2	22.8	21.2	21.2	21.5
ЕБС-ийн хамран сургалтын бохир жин (1-9 р анги)	92.5	93.5	95.1	94.9	95.3
ЕБС-ийн суралцагч-багшийн харьцаа	27.0	21.1	18.5	19.1	18.8
СӨБ-ийн байгууллагын тоо	28	31	40	40	41
СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо (1000 хүүхэд)	5.6	7.1	8.5	8.9	9.1
СӨБ-д ажиллаж байгаа нэг багшид ногдох хүүхэд	54.5	53.7	44.2	45.8	43.6



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн багш 208


Сургуулийн 1 дүгээр ангид элсэгчид 2336




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхэд 9076



ЕБС-д суралцаж байгаа малчин өрхийн хүүхэд 8893, үүнээс эмэгтэй 4529



- ЕБС-д суралцагчдаас дотуур байранд суух хүсэлт гаргасан
- Амьдарч буй хүүхэд



ЕБС-д суралцаж байгаа малчин өрхийн хүүхэд




ЕБС-ийн үндсэн багш 1145



Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид



ЕБС, СӨБ-ийн байгууллагын тоо, сумдаар, 2017/2018 хичээлийн жилд





Малын тоо


Төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бодоор *	462922	558334	684717	817625	978155	1096212	1274786	1423965
Толгойн тоо	2010557	2425649	2970688	3486043	4111515	4510986	5208582	5743530
Тэмээ	14707	15873	18134	19740	21970	23128	26251	28756
Адуу	113800	141099	170536	205881	246950	280197	323363	364015
Үхэр	76230	90567	113966	144926	183265	217599	259939	298244
Хонь	896623	1051754	1310889	1541304	1821050	2021762	2378488	2663296
Ямаа	909197	1126356	1357163	1574192	1838280	1968300	2220541	2389219

*Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг 1 бод, тэмээг 1.5 бод, 6 хонь 8 ямааг тус бүр 1 бод гэж тооцов. 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Өвөрхангай аймгийн 19 сумын 109 багт 5.7 сая толгой мал тоолуулж 2016 оныхоос 534.9 мянган толгой малаар буюу 10.3 хувиар өссөн байна. Мал сүрэг таван төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна.




Өрх, малчдын тоо, насны бүтэц, тэдний соёл, ахуйн байдал

Төрөл	2013	2014	2015	2016	2017
Малтай өрх	17595	17925	17959	18520	18956
Малчин өрх	13570	14115	14658	15407	16087
Малчдын тоо	26254	27580	28446	29993	28265
16-34 насны	10498	10720	10857	11087	10162
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	13055	13854	14594	15757	14252
Тэтгэврийн насны	2701	3006	2995	3149	3851
Нийт малчдаас эмэгтэй	12561	13073	13436	14083	12417
Насны бүрэлдэхүүн хувь	100	100	100	100	100
16-34 насны	39.3	38.9	38.2	37.0	36.0
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	48.9	50.2	51.3	52.5	50.4
Тэтгэврийн насны	10.1	10.9	10.5	10.5	13.6
Нийт малчдаас эмэгтэй хувь	47.8	47.4	47.2	46.9	43.9
Нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойгоор/	257	291	308	338	357

Малын тоо,
сумдаар



Мал сүргийн бүтэц, 2017 он



Нийт малын дотор хонин сүрэг 46.4 хувь, ямаан сүрэг 41.6 хувь, адуун сүрэг 6.3 хувийг тус тус эзэлж байна.



2017 оны жилийн эцсийн мал тооллогын үр дүнд Өвөрхангай аймгийн хэмжээнд 5743530 толгой мал тоологдсон байна.



364015

28756



2663296



298244



2389219





Хамгийн олон малтай сумд



Богд 454726

Баянгол 426123

Баян-Өндөр 412057


Бүрд 364392


Уянга 349956









Малын төрлөөр нь авч үзвэл:
















Тариалсан талбай нийт 8826.2 (га)


- Үр тариа 8217.5
- Хүнсний ногоо 213.6
- Төмс 395.1
- Тэжээлийн ургамал 651.7
- Бэлтгэсэн өвс хадлан 32604.2


Хураасан ургац (тонн)


- Үр тариа 2113
- Хүнсний ногоо 2020.0
- Төмс 3917.6
- Тэжээлийн ургамал 1506.3













АРЦ БОГД УУЛ



Өвөрхангай аймгийн Богд сумын нутагт орших Арц богд уул нь Бага Богд уулын зүүн хоолойгоор зааглагдаж, баруун үзүүр нь Бага Богд уултай 20 гаруй километр газраар зөрсөн байдаг. Уулсын ар тал нь эгц, нилээд хадархаг говийн шинжтэй.

Ноён оргил нь далайн төвшнөөс дээш 2477 метр өндөр Их баян уул. Уулын өвөр тал нь нилээд налуу, олон салбар уулстай. Тухайлбал, Дулаан богд уул 2094 метр, Зост уул 1580 метр, салбар уулсын зүүн хэсэг нь Халзан хайрхан уулаар төгсдөг.

Ийнхүү Арц Богд уул нь салбар уулсын хамт 180 километр үргэлжилдэг. Зүүн өвөрт нь Их булаг, Бага булаг, Бумба, Сөөг, Туруухай, Цагаан хад, Баруун Зүүн хөөвөр гэх мэт задгай устай. Харин баруун өвөртөө Авдрантай, Зүүн баруун Ялаатай, Гэгээт, Ямаан ус, Харангад, Хөөвөр, Мансруй зэрэг задгай устай. Ийм их гол горхи булаг шандтай учраас Арц богд ууланд жилийн дөрвөн улиралд манан татаж, хур буун эдгээр усан сангуудаа эргээд усаар тэтгэж байдаг, алтан дуулгат хайрхан юм.



ХУЖИРТ РАШААН



Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутаг, Орхон голын сав газарт, Хангайн нурууны салбар Шунхлай, Гуа, Шивээт уулсын дунд далайн төвшнөөс дээш 1600 метрт, Улаанбаатараас 390 км-т оршдог.

Карбонат-сульфат-натри-кальцийн найрлагатай, фторт азотын халуун рашаан бөгөөд үе мөч, арьсны өвчин, ясны гэмтэл, эмэгтэйчүүд, мэдрэлийн өвчний үед голдуу хэрэглэнэ. Мөн эмчилгээний хүчин зүйлийн нэг бол лаг хар шавар бөгөөд үе мөч болон арьсны зарим өвчний үед хэрэглэнэ.

Эмчилгээг шавраар, усаар, зүүгээр, бариа заслаар, мөн физик эмчилгээний аргаар зохион байгуулдаг. Тархины судасны хатуурлын гүнзгийрсэн хэлбэр, дахилттай болон хүндрэлтэй явцтай өөрөөр хэлбэл, кардиогены шок, хүнд хэм алдагдал, зүрхний шигдээсийн дараах үе, артерийн даралт ихдэлтийн өвчин ИБ түүнээс дээд шат, зүрхний бахын байнгын болон хүнд хэлбэрийн илэрлийн үед энэ рашаан зохимжгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Хужирт рашаан сувилал нь байнгын ажиллагаатай бөгөөд нэг ээлжиндээ 350-600 хүн хүлээн авах хүчин чадалтай.



МОНГОЛ ТҮМНИЙ МОРИНЫ ИХ ШҮТЭЭН



Монгол түмний морины их шүтээн Өвөрхангай аймгийн Арвайхээр сумаас 15 километр газарт буюу алдарт Арвайн талд байрладаг. Энэхүү цогцолборыг 2007 оны наймдугаар сард олны хүртээл болгосон байдаг. Шүтээнийг босгосон газрын нэр нь Баян толгой бөгөөд эрт дээр үеэс хурдан морь уядаг хүмүүс тахиж шүтэж ирсэн төдийгүй алдарт Аравгар хээр хэмээх хурдан хүлгийн төрж өссөн газар ажээ.

Их шүтээний төв хэсгийн талбайн диаметр нь 10 метр, хүндэтгэлийн хоёр багана нь таван метр өндөртэй бөгөөд түүн дээр их шүтээнийг босгоход хувь нэмэр, хандив туслалцаа өргөсөн байгууллага хүмүүсийн нэрсийг мөнхжүүлэн бичжээ. Хагас тойрог хэсэгт 12 багана босгож, хойморт нь гурван метр өндөр Дамдинянсан буюу хурдан морины сахиус бурхан Хаянхярвааг бүтээж шилэн гуунд байрлуулжээ. Төв дунд нь газар газрын хурдан морины төлөөлөл болгон алдарт Аравгар хээрийн хөшөөг босгож, хүрд ба сангийн бойпор байрлуулсан аж.



ЭРДЭНЭ ЗУУ ХИЙД



Монгол улс дахь хамгийн эртний Буддын шашны хийд юм. Хархорин хотын туурин дээр үлдсэн чулуун ханыг зөөж авчраад одоогийн Эрдэнэзуу хийдийг босгосон түүхтэй. 1580 онд Автай сайн хаан, дүү Түмэнхэн ноёнтон хамт III Далай ламтай уулзаж, түүний зөвлөсөн дагуу Хархорум хотын нэгэн хуучин сүм болох Тахай балгасан дахь сүмийг сэргээснээр суурь нь тавигджээ.

Ийнхүү 1586-1674 онд Гурван зуу сүм, Ригсүм Гомбо сүмүүдийг, 1701-1705 онд Очирдарь сүм, Авид сүм, Их суварганы чуулбаруудыг, 1771-1792 онд Цогчин их дуган, Лаврин сүмүүдийг тус тус бариулжээ. 1796 онд Эрдэнэзуу хийд анх удаа их засварт орсон бөгөөд 7 дугаар ширээт лам Дагвадаржаа ламтан удирдаж хятадын Юн-да-а пүүс гүйцэтгэл хийжээ. Энэ засварын үеэр хуучин Тахай балгасны хэрмэн нурангийг суурь болгон 50 ширхэг суварга босгосон байна.

1802-1813 онд ноёд тайж, лам хувраг, сүсэгтэн ардын хөрөнгөөр өмнө барьсан суваргуудын завсар хооронд 56 суварга нэмж хэрмэн ханыг барьж дуусгасан байна. Өдгөө хийдийг тойрон хүрээлэх 108 суварга бүхий хэрмэн хашаа нь хааш хаашаа 420 метр юм. 1782 онд 50 хувраг сурагчтайгаар Бодь мөрийн сургуулийг байгуулжээ. Монголын ноёд, язгууртнууд хэрмийн дотор өөрийн дугантай байх нь нэр төрийн хэрэг гэж үздэг байсан учраас Түшээт ханы болон ноён Цэвээнжавын дуган, Очирдарийн дуган гэх мэт олон сүм дуган баригдан 1792 он гэхэд 62 сүм, 500-гаад барилга байшинтай, 10 мянган ламтай болж өргөжсөн байна.



ТӨВХӨН ХИЙД



Өвөрхангай, Архангай аймгийн нутгийн заагт Хужирт сумын төвөөс баруун хойшоо 40 километр, Бат-Өлзийт сумын төвөөс 50 километр зайтай Өндөр-Овоот буюу Шивээт-Улаан хэмээх аглаг ой модоор хүрээлэгдсэн асга хадтай өндөр уулын оройн байц хадны багавтар дэвсэг дээр оршдог.

Уулын бэлээс хийд хүртэл 5 километр өгсөж хүрнэ. Монголын анхдугаар Богд Занабазар 1648 онд 14 настайдаа энэхүү байгалийн сонин сайхан өвөрмөц тогтоцтой газрыг сонирхон таалж, 1651 онд бясалгал үйлдэх чулуун ханатай жижиг байшин бариулсан бөгөөд түүнийг “дубхан” буюу бүтээх байр гэж нэрлэжээ. Энэ үг нь сунжирсаар өдгөө Төвхөн болсон байна. Өндөр гэгээн Занабазар тус хийдэд сууж байхдаа 1686 онд “Соёмбо” үсгээ зохиож, “Адистэдийн дээдийг хайрлагч” тэргүүтэй зохиолоо айлдахын сацуу “Тэргүүний нь үс ургаж байсан” гэгдэх гайхамшигт шүтээн дүрээ бүтээж, ур ухааны оргил болсон хосгүй нандин бүтээлүүдээ урлажээ.



УЛААН ЦУТГАЛАН



Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд байрлах Улаан цутгалан хүрхрээ нь зуны дэлгэр цагт гадаад, дотоодын аялагч, жуулчдын үзэхийг хүсдэг хамгийн үзэсгэлэнтэй газрын нэг юм. Улаан цутгалангийн тухай домогт ийн өгүүлсэн байдаг. Дайны үед Монголын цэрэг гамингуудад хөөгдөж амь дүйж яваад хайрган дээгүүр гарсан гэнэ. Монгол цэргүүдийн нэг нь номтой гэх бөгөөд тэрээр "Улааны гол минь улаанаар урс" гэж дуу алдан орилоход, Улаан голын дагуу үер буун гамингийн цэргүүдийг аван одсон гэнэ. Хожим түүнээс хойш "Улаан цутгалан" гэж нэрлэх болжээ. Тэгээд тэр хүүрнүүд нэг хөндийд очин цугларсан бөгөөд тэр газрыг хүүртийн хөндий гэх бөгөөд олон жилийн явцад Үүртийн хөндий болжээ.

Өвөрхангай аймгийн Орхон голын баруун биед цутгах Улаан голд үүссэн 20 гаруй метр өндрөөс буух 10 орчим метр өргөн хүрхрээ юм. Орхон гол нь Гятрууны нуруунаас Хархорин сум хүртэлх 130 километр газарт галт уулын хүрмэн чулуун дундуур урсдаг. Дөрөвдөгч галавын үед Хангайн нуруунаас эх авах Цагаан азарга голын эхэнд галт уул дэлбэрэн оргилж түүний халуун хайлмал бодис нь Орхоны хөндийг уруудан урсаж хэдэн арван км зузаан хүрмэн чулуун хучлага үүсгэжээ. Тэр хүрмэн чулуун хучлагыг Орхон гол хөрөөдөж урссаар таслан өнөөгийн энэ хавцлыг үүсгэсэн ажээ. Хүрхрээгээс баруун хойшоо Бага хүрхрээ гэж нэг боргио бий.



ХҮЙСИЙН НАЙМАН НУУР



Хүйсийн Найман нуур нь Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотоос 115 км-т оршдог. Зам маш бартаатай боловч жуулчид энэ бүсэд ихэвчлэн морь унаж баруун хойноос нь ирдэг. Хүйсийн Найман нуур нь Монгол орны төв хэсэг, Хангайн уулсын дунд д.т.д 2400 метрт оршдог. Тус газрын ихэнх хэсэг нь Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт байх агаад баруун талаараа Бат-Өлзий сумтай хиллэдэг. Мөн Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын нэг хэсэг болдог. Хойд талаараа галт уулын чулуулаг тархсан тал газраар хүрээлэгдсэн хүн ам сийрэг суурьшсан газар юм.

Ширээт, Халиут, Бугат, Хаяа, Хүйс, Мухар, Дөрөө, Баян-Уул хэмээн нэрлэгдсэн найман нуур байх бөгөөд хоорондоо газар доор усны судлаар холбогдсон байдаг. Нуурууд хоорондоо 500 метрээс 3 км хүртэл зайтай байдаг. Хүйсийн Найман нуур нь уулын тагийн бүслүүрийн хөрстэй, шилмүүст болон Сибирийн хар мод, ушин ойтой. Хойд талаараа галт уулын чулуулагтай тэгш тал, нүцгэн оройтой уулсаар хүрээлэгдсэн байдаг.

Өвөрхангай аймагтай холбоотой ВЭБ хуудас

- <http://www.uvurkhangai.mn>
- <http://www.uvurkhangai.nso.mn>